

“БЭСТ ФОРТУНА АУДИТ” ХХК

# УВС ХҮНС

ХУВЬЦААТ КОМПАНИ

---

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр  
дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлан

Улаанбаатар хот 2023 он



“УВС ХҮНС” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

## “БЭСТ ФОРТУНА АУДИТ” ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо  
“Урбанек” ХХК-ийн байр 307 тоот  
Утас: 324338, 89116465, 98056465, 98006465  
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2023.04.12 № 89

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

#### **Зөрчилгүй дүгнэлт**

Бид “Увс хүнс” ХК-ийн 2022 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

#### **Дүгнэлтийн үндэслэл**

Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.

#### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага**

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

**Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

ЗАХИРАЛ



Ж. ОЮУНЦЭЦЭГ

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ  
САНХҮҮ БАЙДЛЫН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2022-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	334,304.0	334,304.0
Дансны авлага	100,723.9	100,723.9
Татвар, НДШ-ийн авлага	2,541.5	2,541.5
Бусад авлага	498,666.6	498,666.6
Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Бараа материал	1,870,203.3	1,870,203.3
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	115,117.3	115,117.3
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
Дуусаагүй үйлдвэрлэл	-	-
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус	-	-
Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>2,921,556.5</b>	<b>2,921,556.5</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
Үндсэн хөрөнгө	1,777,269.8	1,777,269.8
Биет бус хөрөнгө	68,873.6	68,873.6
Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>1,846,143.4</b>	<b>1,846,143.4</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>4,767,699.9</b>	<b>4,767,699.9</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ</b>		
<b>Өр төлбөр</b>		
<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
Дансны өглөг	337,522.1	337,522.1
Цалингийн өглөг	32,324.5	32,324.5
Татварын өр	197,780.2	197,780.2
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	95,735.8	95,735.8
Хүүний өглөг	30,108.5	30,108.5
Ногдол ашгийн өглөг	-	-
Урьдчилж орсон орлого	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>693,471.1</b>	<b>693,471.1</b>
Урт хугацаат зээл	1,250,000.0	1,250,000.0
Хойшлогдсон татварын өр	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,250,000.0</b>	<b>1,250,000.0</b>
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>1,943,471.1</b>	<b>1,943,471.1</b>
<b>Эзэмшигчийн өмч</b>		
Өмч: а) Төрийн	-	-
б) Хувийн	-	-
в) Хувьцаат	14,736.7	14,736.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	1,962,071.6	1,962,071.6
<b>Эзэмшигчийн өмчийн дүн</b>	<b>2,824,228.8</b>	<b>2,824,228.8</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн</b>	<b>4,767,699.9</b>	<b>4,767,699.9</b>

БЭЭС ФОРУНА  
АУДИТ ХАК

04 сар  
2023



" Увс хүнс " ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН  
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2022-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
Борлуулалтын орлого	4,135,466.7	4,135,466.7
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,359,143.4	2,359,143.4
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>1,776,323.3</b>	<b>1,776,323.3</b>
Түрээсийн орлого	-	-
Хүүгийн орлого	-	-
Ноогдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	2,730.2	2,730.2
Борлуулалт маркетингийн зардал	212,633.9	212,633.9
Ерөнхий ба удирдлагын зардал	927,813.9	927,813.9
Санхүүгийн зардал	118,953.4	118,953.4
Бусад зардал	10,988.1	10,988.1
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	310.0	310.0
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	-	-
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>508,974.1</b>	<b>508,974.1</b>
Орлогын татварын зардал	51,924.3	51,924.3
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>457,049.8</b>	<b>457,049.8</b>
<b>Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)</b>	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>457,049.8</b>	<b>457,049.8</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
Бусад олз (гарз)	-	-
<b>Орлогын нийт дүн</b>	<b>457,049.8</b>	<b>457,049.8</b>
<b>Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)</b>	-	-

БЭСТ-ФОРТЭНА  
АУДИТ САХ

04/12/2022  
Х.Олов

**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН  
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН**

(мянган төгрөг)

Үзүүлэлт	Өмч	Тэмж төлөгдс өн капита	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлаг- дсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>14,736.7</b>	<b>-</b>	<b>847,420.5</b>	<b>-</b>	<b>1,302,444.9</b>	<b>2,164,602.1</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-	-
Залруулсан үлдэгдэл	14,736.7	-	847,420.5	-	1,302,444.9	2,164,602.1
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					202,576.9	202,576.9
Бусад дэлгэрэнгүй орлого	-				-	-
Өмчид гарсан өөрчлөлт				-	-	-
Зарласан ногдол ашиг					-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		-			-
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>14,736.7</b>	<b>-</b>	<b>847,420.5</b>	<b>-</b>	<b>1,505,021.8</b>	<b>2,367,179.0</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт						-
Залруулсан үлдэгдэл	14,736.7	-	847,420.5	-	1,505,021.8	2,367,179.0
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					457,049.8	457,049.8
Бусад дэлгэрэнгүй орлого	-				-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-				-	-
Зарласан ногдол ашиг	-				-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-		-		-	-
<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>14,736.7</b>	<b>-</b>	<b>847,420.5</b>	<b>-</b>	<b>1,962,071.6</b>	<b>2,824,228.8</b>

" Увс хүнс " ХК

2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН  
ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(мянган төгрөг)

Үзүүлэлтүүд	2022-12-31	
	Аудитлагдаагүй	Аудитлагдсан
<b>Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>4,519,668.7</b>	<b>4,519,668.7</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,518,440.2	4,518,440.2
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,228.5	1,228.5
Буцаан авсан албан татвар	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,140,523.4</b>	<b>5,140,523.4</b>
Ажиллагсад олгосон мөнгө	573,530.7	573,530.7
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	94,374.4	94,374.4
Бараа, материал худалдан авахад төлсөн	3,339,069.6	3,339,069.6
Ашиглалтын зардалд төлсөн	123,006.4	123,006.4
Түлш, шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгсэлд төлсөн	122,978.2	122,978.2
Хүүний төлбөрт төлсөн	94,812.3	94,812.3
Татварын байгууллагад төлсөн	475,941.1	475,941.1
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	316,810.7	316,810.7
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(620,854.7)</b>	<b>(620,854.7)</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсаны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>104,831.4</b>	<b>104,831.4</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	104,831.4	104,831.4
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
Бусад мөнгөн зарлага	-	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>	<b>(104,831.4)</b>	<b>(104,831.4)</b>
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>600,000.0</b>	<b>600,000.0</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	600,000.0	600,000.0
Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	-	-
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>200,000.0</b>	<b>200,000.0</b>
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	200,000.0	200,000.0
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө	-	-
Бусад мөнгөн зарлага	-	-
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	-	-
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>400,000.0</b>	<b>400,000.0</b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(11.2)</b>	<b>(11.2)</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(325,697.3)</b>	<b>(325,697.3)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>660,001.2</b>	<b>660,001.2</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>334,304.0</b>	<b>334,304.0</b>

БЭСИ-ФОРТУНА АУДИТ ХХК 



ТАЙЛАГНАГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД:	"УВС ХҮНС" ХК
ХАЯГ:	Увс аймаг, Улаангом сум, 5-р баг
ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН ОГНОО:	1942 оны 02 дугаар сарын 18 1992 онд ТӨХорооны шийдвэрээр төрийн өмч давамгайлсан "Чиндмэн" ХК, 1999 онд Бүтэц зохион байгуулалтаа өөрчлөн "Увс хүнс" ХК болсон.
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ДУГААР:	1510001008
РЕГИСТРИЙН ДУГААР:	2001969
ӨМЧИЙН ХЭЛБЭР:	Хувьцаат компани
ҮЙЛ АЖИЛЛААГААНЫ ЧИГЛЭЛ:	<ul style="list-style-type: none"> <li>• 1101 Спирт, архи зэрэг согтууруулах ундаа үйлдвэрлэл</li> <li>• 1074 Гоймон, пүнтүүз болон энэ төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li> <li>• 0125 Жимс, жимсгэнэ тариалалт</li> <li>• 4630 Ундаа, цэвэр усны үйлдвэрлэл</li> <li>• 1071 Талх, талхан бүтээгдэхүүн үйлдвэрлэл</li> <li>• 1080 Жимс, ногоо боловсруулах, хадгалах</li> </ul>
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ:	14,736,726.00 төгрөг
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ	ХХААХҮ-ийн сайдын 2010 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/152 дугаар тушаалыг үндэслэн "Архины үйлдвэрлэл"-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ:	Л.Нямгэрэлийг ТУЗ-ийн 22/09 дугаартай тогтоолоор 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрөөс гүйцэтгэх захирлаар томилсон.
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ:	Б.Дэлгэрмааг 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 20/50 дугаар тушаалаар нягтлан бодогчоор томилсон.



## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	(мянган төгрөгөөр)	
	2021/12/31-ний үлдэгдэл	2022/12/31-ний үлдэгдэл
<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>Эргэлтийн хөрөнгө</b>	<b>3,476,546.9</b>	<b>2,921,556.5</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	660,001.3	334,303.9
Богино хугацаат хөрөнгө оруулалт		
Дансны авлага	79,067.9	100,723.9
Татвар, НДШ-ийн авлага	31,023.6	2,541.5
Бусад авлага	946,992.3	498,666.6
Бараа материал	1,510,133.6	1,870,203.3
Урьдчилж төлсөн зардал	249,328.2	115,117.3
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>1,573,540.4</b>	<b>1,846,143.4</b>
Үндсэн хөрөнгө	1,573,540.4	1,777,269.8
Биет бус хөрөнгө	-	68,873.6
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>5,050,087.3</b>	<b>4,767,699.9</b>
<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>1,732,908.3</b>	<b>693,471.1</b>
Дансны өглөг	886,708.3	337,522.1
Цалингийн өглөг	22,177.0	32,324.5
Татварын өглөг	115,832.8	197,780.2
НДШ-ийн өглөг	1,936.1	
Банкны богино хугацаат зээл	650,000.0	95,735.8
Хүүний өглөг	7,296.6	30,108.5
Урьдчилж орсон орлого	29.9	
Бусад богино хугацаат өр төлбөр	48,927.6	
<b>Урт хугацаат өр төлбөр</b>	<b>950,000.0</b>	<b>1,250,000.0</b>
Бусад урт хугацаат өр төлбөр	950,000.0	1,250,000.0
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,682,908.3</b>	<b>1,943,471.1</b>
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>		
Өмч: а) төрийн		
б) хувийн		
в) хувьцаат	14,736.7	14,736.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5
Хуримтлагдсан ашиг	1,505,021.8	1,962,071.6
<b>ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,367,179.0</b>	<b>2,824,228.8</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,050,087.3</b>	<b>4,767,699.9</b>

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	(мянган төгрөгөөр)	
	2021/12/31-ний үлдэгдэл	2022/12/31-ний үлдэгдэл
<b>Борлуулалтын орлого</b>	<b>4,179,403.6</b>	<b>4,135,466.7</b>
Борлуулалтын өртөг	3,011,256.0	2,359,143.4
<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>1,168,147.6</b>	<b>1,776,323.3</b>
Хүүний орлого	179.1	-
Бусад орлого	-	2,730.2
Борлуулалт маркетингийн зардал	-	212,633.9
Ерөнхий ба удирдлагын зардал	936,460.2	927,813.9
Санхүүгийн зардал	-	118,953.4
Бусад зардал	6,562.6	10,988.1
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(0.9)	309.9
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	491.7	-
Бусад ашиг (алдагдал)		
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>225,794.7</b>	<b>508,974.1</b>
Орлогын татварын зардал	23,217.8	51,924.3
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>202,576.9</b>	<b>457,049.8</b>
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
<b>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</b>	<b>202,576.9</b>	<b>457,049.8</b>

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

## ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>14,736.7</b>	<b>847,420.5</b>	-	<b>1,302,444.9</b>	<b>2,164,602.1</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	14,736.7	847,420.5		1,302,444.9	2,164,602.1
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				202,576.9	202,576.9
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
<b>2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>14,736.7</b>	<b>847,420.5</b>	-	<b>1,505,021.8</b>	<b>2,367,179.0</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
Залруулсан үлдэгдэл	14,736.7	847,420.5	-	1,505,021.8	2,367,179.0
Бусад дэлгэрэнгүй орлого					-
Өмчид гарсан өөрчлөлт					-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				457,049.8	457,049.8
<b>2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>14,736.7</b>	<b>847,420.5</b>	-	<b>1,962,071.6</b>	<b>2,824,228.8</b>

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно



## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31-ний үлдэгдэл	(мянган төгрөгөөр) 2022/12/31-ний үлдэгдэл
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(4,701.3)</b>	<b>(620,854.7)</b>
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	4,856,558.6	4,519,668.7
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,856,558.6	4,518,440.2
Буцаан авсан албан татвар		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		1,228.5
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага</b>	<b>4,861,259.9</b>	<b>5,140,523.4</b>
Ажиллагсад олгосон	453,458.4	573,530.7
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	95,000.0	94,374.4
Бараа материал худалдан авахад төлсөн	3,816,880.8	3,339,069.6
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	11,491.1	123,006.4
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	56,712.9	122,978.2
Хүүний төлбөрт төлсөн	78,861.9	94,812.3
Татварын байгууллагад төлсөн	348,854.8	475,941.1
Бусад мөнгөн зарлага	-	316,810.7
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>(139,809.4)</b>	<b>(104,831.4)</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлого	1,679.1	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого	1,500.0	-
Хүлээн авсан хүүний орлого	179.1	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	141,488.5	104,831.4
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	141,488.5	104,831.4
Бусад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа		-
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>685,526.4</b>	<b>399,988.8</b>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	1,100,000.0	600,000.0
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	1,100,000.0	600,000.0
Бусад орлого		
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	414,473.6	200,011.2
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	414,473.6	200,000.0
Валютын ханшийн зөрүү		11.2
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>541,015.7</b>	<b>(325,697.3)</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>118,985.5</b>	<b>660,001.2</b>
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>660,001.2</b>	<b>334,303.9</b>

Холбогдох нэмэлт тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

**АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТОДРУУЛГА**

2022.12.31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлангийн тухай)

"Увс хүнс" ХК-нь анх 1942 оны 02 дугаар сарын 18-ны өдөр "Идэш тэжээлийн комбинат" нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 1973 оноос Хүнсний комбинат болон өргөжиж, 1992 онд Төрийн өмчийн хорооны шийдвэрээр төрийн өмч давамгайлсан "Чиндмэн" хувьцаат компани болон зохион байгуулагдсан байна. Улмаар 1999 онд бүтэц зохион байгуулалтаа өөрчлөн "Увс хүнс" хувьцаат компани болон өнөөг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна. "Увс хүнс" хувьцаат компани нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 112 716 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх дүрмийн сантай, 1 үүсгэн байгуулагчтай ажиллаж байна.

"Увс хүнс" ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын Олон Улсын стандарт /АОУС/, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах хорооны холбогдох журам, шийдвэрүүдийн хүрээнд шалгаж танилцлаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлан нь зөвхөн 2022 оны жилийн эцсийн хөрөнгө, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг тусган үзүүлж байгаа болно. Байгууллагын удирдлагаас санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэж, орлого ба зардлыг акрузель суурьт зарчмаар хүлээн зөвшөөрсөн.

"Увс хүнс" ХК-ийн тайлант оны орлого, зарлагын төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор баталж, гүйцэтгэлийг тайлагнан ажилласан байна.

"Увс хүнс" ХК нь нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Сангийн яамнаас гаргасан заавар, журмуудыг баримталж байна.

Тайлант онд үндсэн үйл ажиллагааны борлуулалтын орлого 4,135,466.7 мянга, бусад орлого 2,730.2 мянга, гадаад валютын ханшийн зөрүүний олз 310.0 мянга, нийт 4,138,506.9 мянган төгрөгийн орлого, 1,270,389.3 мянган төгрөгийн зардал, 508,974.1 мянган төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашиг хүлээн зөвшөөрч нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

**1. Мөнгөн хөрөнгө**

Байгууллагын мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, харилцах данснаас бүрдсэн ба мөнгөн хөрөнгүүдийг валютын төрөл, зориулалт, байршлаар ангилан, нэрлэсэн үнээр үнэлж тэнцэлд тусгасан байна. Бид мөнгөн хөрөнгийн дансуудын тайлант оны гүйлгээ ба үлдэгдлийг аудитын түүврийн ба тулган баталгаажуулалтын аргаар тестлэн шалгаж дараах мэдээллийг олж тогтоов. Үүнд:

**Касс дахь бэлэн мөнгө**

/мянган төгрөгөөр/

Төрөл		2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>				
Касс	₮	1,075.4	7,814.2	6,738.80
Касс	RUB	-	72.8	72.80
			1.5	1.5
<b>Кассын дүн</b>		<b>1,075.4</b>	<b>7,887.0</b>	<b>6,811.6</b>



## Банкин дахь харилцах данс

(мянган төгрөгөөр)

Банк	валют	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
Голомт банк	₮	2,788.8	1,038.1	(1,750.7)
Голомт банк	RUB	-	44.6	44.6
Худалдаа хөгжлийн банк 499104921	₮	125.9	125.9	-
Худалдаа хөгжлийн банк 499130735	\$	2,260.5	2,732.7	472.2
Хаан банк 5822193252	₮	618.9	320,482.2	319,863.3
Хаан банк 5822414547	₮	4.0	-	(4.0)
Хаан банк 5822353401	RUB	2,287.4	36.5	(2,250.9)
Төрийн банк 162000888885	₮	650,139.5	338.3	(649,801.2)
Төрийн банк 240305830309	\$	69.6	68.0	(1.6)
Төрийн банк 240309932703	RUB	402.0	497.1	95.1
Хас банк 5000499620	₮	88.1	18.3	(69.8)
Хас банк 5004497454	₮	9.0	847.7	838.7
Хас банк 5005393737	\$	-	154.7	154.7
Хас банк 5002910050	CNY	132.1	32.8	(99.3)
<b>Банкин дахь харилцахын дүн</b>		<b>658,925.8</b>	<b>326,416.9</b>	<b>(332,508.9)</b>

Тайлант оны эцэст банкин дахь харилцах дансны үлдэгдэл 332,508.9 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн банкнаас өмнөх оны эцэст авсан зээлийг үйлдвэрлэлд зарцуулсан, богино хугацаат зээлийн үлдэгдлийг төлж барагдуулсанаас шалтгаалсан байна.

## 2. Авлага

Авлагыг дансны авлага, хувь хүнээс авах авлага, борлуулагч худалдагчийн тооцооны авлага, банкнаас авах поссын авлага, ажилчдаас авах авлага, НДШ-ийн авлага, НӨАТ-ын авлага, онцгой татварын авлага, холбоотой талаас авах авлага, цалингийн урьдчилгаа, бусад богино хугацаат авлага гэж ангилан, нэрлэсэн үнээр бүртгэлд тусгасан ба авлагуудын тооцоолол, хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, заавар аргачлалын зарчимд нийцэж байна. Мэдээллийг ашиглан дараах мэдээллийг бэлтгэв.

(мянган төгрөгөөр)

	Авлагын төрөл	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
1	Дансны авлага	79,068.0	100,723.9	21,655.9
2	Ажилчдаас авах авлага	53,510.6	27,820.2	-25,690.4
3	Холбоотой талаас авах авлага	893,481.7	470,846.4	-422,635.3
4	НӨАТ-ын авлага	8,386.3	0.0	-8,386.3
5	НДШ-ийн авлага	0.0	2,541.5	2,541.5
6	Онцгой АТ-ын авлага	22,637.3	0.0	-22,637.3
	<b>Дансны авлагын дүн</b>	<b>1,057,083.9</b>	<b>601,932.0</b>	<b>-455,151.9</b>

Тайлант оны эцэст авлага өмнөх оноос 455,151.9 мянган төгрөгөөр буурахад холбоотой талаас авах авлага буурсан нь нөлөөлсөн байна.



## 3. Урьдчилж төлсөн зардал, тооцоо

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
Урьдчилж төлсөн зардал	6,335.5	2,400.0	(3,935.50)
Урьдчилж төлсөн тооцоо /гатаан авалт/	242,992.7	112,717.3	(130,275.40)
<b>Урьдчилж төлсөн тооцооны дүн</b>	<b>249,328.2</b>	<b>115,117.3</b>	<b>-134,210.9</b>

Тайлант онд урьдчилж төлсөн тооцооны үлдэгдэл 134,210.9 мянган төгрөгөөр буурсан нь С.Дэлгэрээс авах 128,133.6 мянган төгрөгийн тооцоо барагдсанаас шалтгаалсан байна.

## 4. Бараа материал

(мянган төгрөгөөр)

д/д	Төрөл	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
1	Түүхий эд материал	939,597.1	1,100,909.0	161,311.9
2	Дуусаагүй үйлдвэрлэл	-	-	-
3	Бараа, бэлэн бүтээгдэхүүн	321,533.4	667,369.5	345,836.1
4	Хангамжийн материал	249,003.1	58,112.1	(190,891.0)
5	Сэлбэг хэрэгсэл	-	43,812.7	43,812.7
	<b>Бараа материалын дүн</b>	<b>1,510,133.6</b>	<b>1,870,203.3</b>	<b>360,069.7</b>

Тайлант онд түүхий эд материал, хангамжийн материалын үлдэгдэл өмнөх оноос 360,069.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь түүхий эд материалын нөөцөө бүрэн ашиглаж Увс нуур, Ханхөхий нэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж нөөц үүсгэсэнтэй холбоотой байна. Тайлант онд сэлбэг хэрэгслийн үлдэгдлийг хангамжийн материалын үлдэгдлээс салгаж тайлагнасан байна.

## 5. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгүүдийг түүхэн өртгөөр үнэлж, төрөл ба зориулалтаар нь ангилан нэрийн дансанд бүртгэж ашиглах хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлэн, дэлгэрэнгүй бүртгэлүүд ба тэнцэлд хөрөнгийн анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг зэрэгцүүлэн үзүүлсэн байна.

Тайлант онд үйлдвэрийн барилгад хийсэн 126,407.7 мянган төгрөгийн их засварын ажлыг капиталжуулан, нийт 424,242.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл, бусад үндсэн хөрөнгө орлогод авч, 247,384.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассан байна.

Энэ нь холбоотой тал болох Хархираан хөгжил ХХК-с үйл ажиллагааны чиглэлийн дагуу үндсэн хөрөнгө шилжүүлэн авсан болон шилжүүлэн өгсөнтэй холбоотой байна.

Тайлангийн жилд нийт 278,556.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулж, удирдлагын зардлаар бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн анхны өртгийн бүртгэлд материаллаг алдаа илрээгүй бөгөөд харин тооцоолсон нийт элэгдлийг удирдлагын зардалд бүртгэсэн 2021 оны алдааг давтан гаргасан байна. Тайлангийн эхний ба эцсийн үлдэгдлүүдийг дор үзүүлэв.

(мянган төгрөгөөр)

Хөрөнгө	анхны өртөг		хуримтлагдсан элэгдэл		үлдэгдэл өртөг	
	12/31/2021	12/31/2022	12/31/2021	12/31/2022	12/31/2021	12/31/2022
Үндсэн хөрөнгө	3,410,275.2	3,713,541.5	1,836,734.8	1,936,271.7	1,573,540.4	1,777,269.8
Биет бус хөрөнгө	0.0	83,400.0	0.0	14,526.4	0.0	68,873.6
<b>ДҮН</b>	<b>3,410,275.2</b>	<b>3,796,941.5</b>	<b>1,836,734.8</b>	<b>1,950,798.1</b>	<b>1,573,540.4</b>	<b>1,846,143.4</b>

## 5. Өр төлбөр

Богино хугацаат өр төлбөрийг нэрлэсэн үнэ цэнээр үнэлж, харилцагч байгууллага хуулийн этгээд бүрээр данс нээж хөтлөн тайлангийн эхний ба эцсийн өдрөөрх богино хугацаатай өглөгүүдийг дараах дүнгээр илэрхийлж анхан шатны болон хураангуй бүртгэлүүдэд тусгасан байна. Үүнд:

(мянган төгрөгөөр)

	Төрлүүд	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
1	Дансны өглөг	886,708.3	337,522.1	- 549,186.2
2	Цалингийн өглөг	22,177.0	32,324.5	10,147.5
3	НДШ-ийн өглөг	1,936.1	-	- 1,936.1
4	ОАТ-ын өглөг	23,217.8	51,924.3	28,706.5
5	ХХОАТ-ын өглөг	9,516.6	29,323.1	19,806.5
6	НӨАТ-ын өглөг	74,430.8	58,124.4	- 16,306.4
7	Онцгой татварын өглөг	8,439.9	58,137.1	49,697.2
8	Бусад татварын өглөг	227.7	271.3	43.6
9	Богино хугацаат зээл	650,000.0	95,735.8	- 554,264.2
10	Хүүний өглөг	7,296.6	30,108.5	22,811.9
11	Урьдчилж орсон орлого	29.9	-	- 29.9
12	Бусад өглөг	48,927.6	-	- 48,927.6
13	Урт хугацаат зээл	950,000.0	1,250,000.0	300,000.0
	<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>2,682,908.3</b>	<b>1,943,471.1</b>	<b>-739,437.2</b>

Өр төлбөрийн бүртгэл, үлдэгдлийн тооцоолол материаллаг алдаагүй гэж үзэж байна. Өглөгийн үлдэгдэл нийт дүнгээрээ 739,437.2 мянган төгрөгөөр буурсан нь холбоотой талд өгөх өглөгийн 549,186.2 мянган төгрөг, богино хугацаат зээлийн 554,264.2 мянган төгрөгийг барагдуулсан нь голлон нөлөөлсөн ба урт хугацаат зээл 300,000.0 мянган төгрөгөөр татварын өглөг 81,947.4 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

## 6. Эзэмшигчийн өмч

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31
Хувьцаат капитал	14,736.7	14,736.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	847,420.5	847,420.5
Хуримтлагдсан ашиг	1,505,021.8	1,962,071.6
<b>ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,367,179.0</b>	<b>2,824,228.8</b>

Тайланд онд өмчид өөрчлөлт ороогүй бөгөөд санхүүгийн үр дүнгээр хуримтлагдсан ашиг 457,049.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

## 7. Орлого, үр дүн

(мянган төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021.12.31	2022.12.31	Өөрчлөлт
Үйл ажиллагааны орлогын дүн			
Борлуулалтын орлого	4,179,403.6	4,135,466.7	(43,936.9)
Хүүний орлого	179.1	-	(179.1)
Бусад орлого		2,730.2	2,730.2
Үйл ажиллагааны зардлын дүн	3,947,716.2	3,499,591.2	(448,125.0)
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,011,256.0	2,359,143.4	(652,112.6)



Ерөнхий ба удирдлагын зардал	936,460.20	927,813.9	(8,646.3)
Борлуулалт маркетингийн зардал	-	212,633.9	212,633.9
<b>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ҮР ДҮН</b>	<b>202,576.9</b>	<b>457,049.8</b>	<b>457,049.8</b>

Өмнөх оноос орлого 43,936.9 мянга, үйл ажиллагааны зардал 448,125.0 мянга, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 652,112.6 мянган төгрөгөөр тус тус буурч, ерөнхий удирдлага, борлуулалт маркетингийн зардал 203,987.6 мянган төгрөгөөр өссөн ба 457,049.8 мянган төгрөгийн ашигтай гарсныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Тайлант оны борлуулсан бүтээгдэхүүний өртөг, борлуулалт өмнөх онтой харьцуулахад харьцангуй их буюу 21.7 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь өмнөх оны борлуулалт, өртөгт 1.3 тэрбум төгрөгийн үйлдвэрлэлийн бус бараа импортлож нийлүүлсэн нь нөлөөлсөн байна.

Аудитын сонголтот түүвэр ба бусад аргаар гүйцэтгэсэн сорилын үр дүнг үндэслэн байгууллагын үр дүнгийн тайлангаар тодорхойлогдсон орлого, зарлага, үр дүн нь материаллаг алдаа агуулаагүй гэж үзэж байна.

## 8. Ерөнхий ба удирдлагын зардал

(мянган төгрөгөөр)

	ҮЗҮҮЛЭЛТ	Ерөнхий ба удирдлагын зардал		Борлуулалт, маркетингийн зардал	
		2021.12.31	2022.12.31	2021.12.31	2022.12.31
1	Үндсэн болон нэмэгдэл цалин	390,104.4	410,760.4	-	113,643.8
2	Нийгмийн даатгалын шимтгэл	38,962.0	44,599.6	-	13,819.0
3	Албан татвар, төлбөр, хураамжийн зардал	29,627.3	1,875.1	-	-
4	Албан томилолтын зардал	370.0	6,244.0	-	731.0
5	Мэргэжлийн үйлчилгээний зардал	6,177.2	17,388.5	-	-
6	Сургалтын зардал	2,380.4	1,078.2	-	-
7	Элэгдлийн зардал	217,910.8	211,872.0	-	-
8	Түрээсийн зардал	8,168.6	9,829.1	-	4,980.0
9	Ашиглалтын зардал	18,544.8	23,258.4	-	6,408.6
10	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	15,533.4	12,130.5	-	3,376.0
11	Засвар үйлчилгээний зардал	59,663.2	91,839.1	-	23,645.9
12	Бичиг хэргийн зардал	8,569.9	3,665.5	-	3,084.8
13	Шуудан холбооны зардал	6,463.1	6,615.8	-	537.0
14	Шатахууны зардал	22,138.9	21,975.2	-	24,453.0
15	Зээлийн хүүгийн зардал	78,861.9	-	-	-
16	Зар сурталчилгааны зардал	-	1,487.0	-	1,620.2
17	Тээврийн зардал	870.4	731.8	-	45.0
18	Хөдөлмөр хамгааллын зардал	-	2,288.8	-	-
19	Бусад зардал	32,114.0	60,174.9	-	16,289.6
	<b>Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>936,460.3</b>	<b>927,813.9</b>		<b>212,633.9</b>

Тайлант онд ерөнхий ба удирдлагын зардлаас борлуулалт маркетингийн зардлыг салгаж бүртгэсэн ба өмнөх оноос удирдлага, борлуулалт маркетингийн зардал нийт 221,280.5 мянган төгрөгөөр өссөн байна.



## АУДИТОРЫН ЗӨВЛӨМЖ

2023 оны 04 дугаар сарын 10

Улаанбаатар хот

"Увс хүнс" ХК-ийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудит хийж энэхүү товч санал зөвлөмжийг хүргүүлж байна.

### 1. Мөнгөн хөрөнгө

Аудиторын ажиглалт:

Мөнгөн хөрөнгө зарцуулсан анхан шатны баримтын бүрдүүлэлт, эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөл, гарын үсэг, тамга тэмдэг дутуу

Аудиторын зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулж ажиллах;

### 2. Авлага

Аудиторын ажиглалт:

Олон жил болсон, найдваргүй болох эрсдэлтэй, хаяг, байршил тодорхойгүй авлагыг шийдвэрлээгүй. Нийт авлагын дүнд 1 жилээс дээш насжилттай 41,534.9 мянган төгрөгийн авлага байна.

Аудиторын зөвлөмж:

Найдваргүй авлагын нөөц байгуулах замаар эрсдэлээс сэргийлэх талаар өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй

### 3. Бараа материал

Аудиторын ажиглалт:

Шатах тослох материал, нүүрсний зарцуулалтын тайлан гаргаагүй, шууд зардлаар бүртгэсэн

Аудиторын зөвлөмж:

Олгосон шатахуун, нүүрсний зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, норм тогтоон гүйцэтгэлээр зардалд бүртгэж байх

### 4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Аудиторын ажиглалт:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасныг хэрэгжүүлж мэргэжлийн байгууллагатай хамтран Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг сайжруулж боловсруулан, баталж мөрдөх тухай өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй

Аудиторын зөвлөмж:

Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах

#### 4. Хөрөнгийн бүртгэл

Аудиторын ажиглалт:

Байгууллагын эзэмшлийн 9006 м2 газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгах өмнөх аудиторын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Аудиторын зөвлөмж:

Газар эзэмших эрхийг үнэлж биет бус хөрөнгөнд бүртгэх өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлэх

#### 5. Зардлын бүртгэл

Аудиторын ажиглалт:

Дуусаагүй үйлдвэрлэлийн зардлыг шууд хөдөлмөрийн, шууд материалын, үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал гэж санхүүгийн программд ангилан бүртгэсэн боловч үйлдвэрлэлийн нэмэгдэл зардлыг цалин, НДШ, урсгал засвар, элэгдэл, ус, дулаан, цахилгаан, үйлдвэрийн ажилчдын хоол, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, бусад зардал гэх мэт зардлын зүйл ангиар ангилж бүртгээгүй

Аудиторын зөвлөмж:

Өмнөх оны аудитаар өгсөн зардлын ангилалтай холбоотой зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх

#### 6. Өмч, хувьцаа

Аудиторын ажиглалт:

2017 оны 05 сарын 23-ны өдөр Улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрийн хөрөнгийн хэмжээг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 847,420.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж бүртгүүлсэнийг залруулах өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.

Аудиторын зөвлөмж:

Санхүүгийн тайлан, Компанийн дүрэм, Монголын хөрөнгийн биржийн бүртгэлээрх өмчийн 3,465.1 мянган төгрөгийн зөрүү, Улсын бүртгэлийн гэрчилгээнд хийлгэсэн өөрийн хөрөнгийн өөрчлөлтийг шийдвэрлэх.

**ЗӨВЛӨМЖ ӨГСӨН:**

"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

АУДИТОР

Ж.ОЮУНЦЭЦЭГ

Д.АЛТАНЦЭЦЭГ